



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/6/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayar_j@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

1 Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БААЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ц.ЭНХТУЯА ТАНАА

2019.01.29 № _____

танай _____-ны № _____ т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баацагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баацагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баацагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

E:\Usukhuu\STA-2019\13.Баацагаан ИТХ\4.Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Энхтуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын ИТХурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2019 оны 01 дүгээр сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/78 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБООС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБООС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНБООС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баацагаан сумын ИТХурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баацагаан сумын ИТХурал нь “Монгол Улсын төрөөс баримтлах бодлого зах зээлийн эдийн засгийн харилцааны шаардлагатай нутгийн захиргааны үйл ажиллагааг нийцүүлэн, орон нутгийн нийгэм эдийн засгийн асуудлыг бие даан шийдвэрлэн ажиллах чадварыг хөгжүүлэн бэхжүүлэх явдал мөн” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баацагаан сумын ИТХурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурал түүний тэргүүлэгчид, хороо, төлөөлөгчид үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд шуурхай явуулж гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах түүний биелэлтэд тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлнэ.
- Сумын хэмжээнд засаг нийгмийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр болон Засаг даргын хөтөлбөр чиглэлийг цогцолбороор нь хөгжүүлэхэд бодлого үйл ажиллагаагаа чиглүүлж хуулиар олгогдсон бүрэн эрхээ тууштай хэрэгжүүлэх.

Баацагаан сумын ИТХурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баацагаан сумын ИТХурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баацагаан сумын ИТХурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баацагаан сумын ИТХурлын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Баацагаан сумын ИТХурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баацагаан сумын ИТХурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 75.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал гараагүй болно.

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй

2.8.1.1

Байхгүй

2.8.1.2

Байхгүй

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баацагаан сумын ИТХурлын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 71099.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 70897.4 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь 2018 онд 70899.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгалд үйл ажиллагааны зардал зарцуулан 1913.2 төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна..

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баацагаан сумын ИТХурлын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй байна

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,916,340.00	3,110,559.00		
35	БАРАА МАТЕРИАЛ	9,916,340.00	3,110,559.00		
354	Хангамжийн материал	9,916,340.00	3,110,559.00		
35410	Бичиг хэргийн материал	1,123,190.00	1,181,360.00		
35420	Аж ахуйн материал	8,793,150.00	1,929,199.00		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,166,129.81	3,884,737.45		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,166,129.81	3,884,737.45		
392	Биет хөрөнгө	1,166,129.81	3,884,737.45		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,064,892.00	5,064,892.00		
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,064,892.00	-5,064,892.00		
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,022,870.00	6,682,850.00		
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,763,911.53	-4,957,202.82		
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,984,335.00	5,744,335.00		
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,077,163.66	-3,585,244.73		
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00		
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,082,469.81	6,995,296.45		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,082,469.81	6,995,296.45		
51	Засгийн газрын хувь оролцоо	11,082,469.81	6,995,296.45		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,860,220.00	7,860,220.00		
51101	Өмч: - төрийн	7,860,220.00	7,860,220.00		
512	Хуримтлагдсан үр дүн	3,161,554.31	-925,619.05		
51210	Өмнөх үеийн үр дүн	3,161,554.31	3,161,554.31		
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,087,173.36		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,695.50	60,695.50		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,082,469.81	6,995,296.45		

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	80,432,646.00	71,910,400.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	80,432,646.00	71,910,400.00		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	1,011,100.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,011,100.00		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,801,100.00	70,899,300.00		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,801,100.00	70,899,300.00		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,631,546.00	00.00		
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,631,546.00	00.00		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	72,892,539.61	75,997,573.36		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,892,539.61	75,997,573.36		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,142,416.61	74,184,560.13		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,139,527.70	50,340,672.89		

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	51,139,527.70	50,340,672.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,062,675.30	6,050,809.88
210201	Тэтгэврийн даатгал	4,025,288.22	4,106,420.10
210202	Тэтгэмжийн даатгал	345,535.60	503,407.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	473,001.88	402,724.22
210204	Ажилгүйдлийн даатгал	200,156.06	91,513.75
210205	Эрүүл мэндийн даатгал	1,018,693.54	946,744.54
2104	Хангамж, бараа материалын зардал	5,632,680.00	13,188,005.00
210401	Бичиг хэрэг	1,093,360.00	595,950.00
210402	Тээвэр, шатахуун	4,294,320.00	4,994,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	245,000.00	248,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	7,349,950.00
2105	Нормативт зардал	5,146,350.00	1,826,500.00
210502	Хоол, хүнс	5,146,350.00	1,826,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	239,000.00
210604	Урсгал засвар	00.00	239,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	1,194,300.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	1,194,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,350.00	108,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	28,200.00	28,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	132,150.00	80,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,833.61	1,236,372.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,000.00	535,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	640,833.61	701,372.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,750,123.00	1,813,013.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,231,546.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,231,546.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	518,577.00	13,013.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	518,577.00	13,013.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>7,540,106.39</u>	<u>-4,087,173.36</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>7,540,106.39</u>	<u>-4,087,173.36</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>80,432,646.00</u>	<u>71,910,400.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>80,432,646.00</u>	<u>71,910,400.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	1,011,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,011,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,801,100.00	70,899,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,801,100.00	70,899,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	1,631,546.00	00.00

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	санхүүжих		
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,631,546.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	80,432,646.00	71,910,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,432,646.00	71,910,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,682,523.00	70,097,386.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,139,533.00	50,338,748.00
210101	Үндсэн цалин	34,628,240.00	45,787,645.00
210104	Урамшуулал	13,023,325.00	960,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,487,968.00	3,591,103.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,062,670.00	6,052,734.77
210201	Тэтгэврийн даатгал	6,062,670.00	4,075,263.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	495,931.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	395,282.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	99,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	987,058.77
2104	Хангамж, бараа материалын зардал	4,599,670.00	4,717,225.00
210401	Бичиг хэрэг	856,150.00	415,120.00
210402	Тээвэр, шатахуун	3,498,520.00	3,994,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	245,000.00	308,000.00
2105	Нормативт зардал	4,824,550.00	1,396,500.00
210502	Хоол, хүнс	4,824,550.00	1,396,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,653,950.00	3,488,979.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,353,950.00	3,169,979.00
210604	Урсгал засвар	5,300,000.00	319,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.00	1,194,300.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.00	1,194,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,602,150.00	1,108,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,519,950.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	28,200.00	28,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,000.00	80,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	1,800,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,750,123.00	1,813,013.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,231,546.00	1,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,231,546.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	518,577.00	13,013.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	518,577.00	13,013.23

3.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,860,220.00	60,695.50	-5,785,068.50	2,135,847.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,860,220.00	60,695.50	-5,785,068.50	2,135,847.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,829,095.06	1,829,095.06
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,860,220.00	60,695.50	3,161,554.31	11,082,469.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,860,220.00	60,695.50	3,161,554.31	11,082,469.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,087,173.36	-4,087,173.36
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,860,220.00	60,695.50	-925,619.05	6,995,296.45

3.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,801,100.00	77,282,523.00	71,099,100.00	70,897,386.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,801,100.00	77,282,523.00	71,099,100.00	70,897,386.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,801,100.00	77,282,523.00	69,299,100.00	69,097,386.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,362,800.00	51,139,533.00	50,506,200.00	50,338,748.00
210101	Үндсэн цалин	34,739,200.00	34,628,240.00	45,946,200.00	45,787,645.00
210104	Урамшуулал	13,023,600.00	13,023,325.00	960,000.00	960,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,600,000.00	3,487,968.00	3,600,000.00	3,591,103.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,097,700.00	6,062,670.00	6,060,700.00	6,052,734.77
210201	Тэтгэврийн даатгал	6,097,700.00	6,062,670.00	4,075,900.00	4,075,263.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	496,300.00	495,931.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	396,900.00	395,282.00

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	99,200.00	99,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	992,400.00	987,058.77
2104	Хангамж, бараа материалын зардал	4,853,000.00	4,599,670.00	4,725,100.00	4,717,225.00
210401	Бичиг хэрэг	1,053,000.00	856,150.00	416,500.00	415,120.00
210402	Тээвэр, шатахуун	3,500,000.00	3,498,520.00	4,000,000.00	3,994,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	245,000.00	308,600.00	308,000.00
2105	Нормативт зардал	4,825,000.00	4,824,550.00	1,400,000.00	1,396,500.00
210502	Хоол, хүнс	4,825,000.00	4,824,550.00	1,400,000.00	1,396,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,653,900.00	7,653,950.00	3,500,000.00	3,488,979.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,353,900.00	2,353,950.00	3,181,000.00	3,169,979.00
210604	Урсгал засвар	5,300,000.00	5,300,000.00	319,000.00	319,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,306,500.00	1,300,000.00	1,172,100.00	1,194,300.00
210702	Дотоод албан томилолт	1,306,500.00	1,300,000.00	1,172,100.00	1,194,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	602,200.00	602,150.00	135,000.00	108,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	520,000.00	519,950.00	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	28,200.00	28,200.00	54,600.00	28,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	44,000.00	80,400.00	80,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,000.00	10,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500000.00	500000.00	1800000.00	1800000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	1,700,000.00	1,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	100,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600000.00	600000.00	1800000.00	1800000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	600,000.00	1,800,000.00	1,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	600,000.00	600,000.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	1,800,000.00	1,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,801,100.00	77,282,523.00	71,099,100.00	70,897,386.77
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	77,801,100.00	77,282,523.00	71,099,100.00	70,897,386.77

Баацагаан сумын ИТХурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	77,801,100.00	77,282,523.00	71,099,100.00	70,897,386.77
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00	12.00	12.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	09.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	02.00	02.00